

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД СУУРИЛУУЛСАН ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖИД КАРТ
ОЛГОХ, ТАВИГДАХ ШААРДЛАГА, КАРТЫГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмаар тээврийн хэрэгсэлд суурилуусан хяналтын төхөөрөмж(тахограф)-д ашиглах картанд тавигдах шаардлага, картыг бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Жолоочийн, хяналтын ажилтны, засвар үйлчилгээний болон аж ахуйн нэгжийн карт

1. Тахографт дараах төрлийн картуудыг ашиглана. Үүнд:

1) Жолоочийн карт - шифрлэх (криптографик) хэрэгсэл ашиглан жолоочийг таниж баталгаажуулах, жолоочийн үйл ажиллагааны талаарх өгөгдлүүдийг хадгалах үүргийг гүйцэтгэнэ;

2) Хяналтын ажилтны карт - шифрлэх (криптографик) хэрэгсэл ашиглан хяналтын хяналтын байгууллагуудыг таниж баталгаажуулах үүргийг гүйцэтгэнэ;

3) Засвар үйлчилгээний карт - шифрлэх (криптографик) хэрэгсэл ашиглан засвар үйлчилгээний төвийг таниж баталгаажуулах үүргийг гүйцэтгэнэ;

4) Аж ахуйн нэгжийн карт - шифрлэх (криптографик) хэрэгсэл ашиглан тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг таниж баталгаажуулах, тахографын өгөгдлүүд, жолооч нарын картын өгөгдлүүдэд нэвтрэх эрхэд блок (хязгаар) тавих үүргийг гүйцэтгэнэ.

2. Жолоочийн картын нүүр хэсэгт дараах мэдээлэл байна. Үүнд:

Картын төрлийн болон хэрэглэгдэх улсын нэр монгол хэлээр “Монгол Улсын жолоочийн карт” (картын дээд хэсэгт);

Мэдээлэл байрлах хэсгүүд:

байрлал “1.” – жолоочийн овог;

байрлал “2.” – жолоочийн нэр;

байрлал “3.” – жолоочийн төрсөн огноо;

байрлал “4а.” – жолоочийн картын хүчинтэй хугацаа эхлэх огноо;

байрлал “4b.” – жолоочийн картын хүчинтэй хугацаа дуусах огноо;

байрлал “4с.” – жолоочийн картыг үйлдвэрлэгч байгууллагын нэр;

байрлал “5а.” – жолооны үнэмлэхний дугаар;

байрлал “5b.” – жолоочийн картын дугаар;

байрлал “6.” – жолоочийн зураг;

байрлал “7.” – жолоочийн гарын үсэг;

байрлал “8.” – жолоочийн байнгын оршин суух (түр оршин суух) хаяг.

Жолоочийн картын дугаар дараах бүтэцтэй байна: MGL D XXXXXXXXXXXX^{X1 X2},

Тайлбар:

MGL – “МУ” гэсэн тогтсон тэмдэглэгээ;

D – жолоочийн картын тогтсон тэмдэглэгээ;

XXXXXXXXXXXX – жолоочийн картын серийн дугаар арван нэгэн оронтой байх бөгөөд тухайн дугаар нь шинээр карт авах болон шинэчлэх тохиолдолд өөрчлөгдөхгүй.

X¹ – жолоочийн картын солилтын индекс (0-9 ба A-Z утга хэрэглэгдэнэ) байх бөгөөд жолоочийн карт нөхөн олгогдсон тохиолдолд өснө. Харин жолоочийн карт шинэчлэгдсэн (шинэ хугацаатай олгосон) тохиолдолд энэхүү индекс тэглэгдэнэ;

X² – жолоочийн картын шинэчлэлийн индекс (0-9, A-Z утга хэрэглэгдэнэ) байх бөгөөд жолоочийн картыг шинэ хугацаагаар олгох тохиолдолд энэхүү индекс дарааллан өснө.

3. Жолоочийн картын ар хэсэгт дараах мэдээлэл байрлана. Үүнд:

- Энэ журмын 2-д дурьдсан байршлуудын тэмдэглэгээ;
- жолоочийн картыг үйлдвэрлэгч байгууллагын мэдээлэл, албан ёсны хаяг.

4. Аж ахуйн нэгжийн картын нүүр хэсэгт дараах мэдээлэл байрлана. Үүнд:

1968 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Замын хөдөлгөөний тухай конвенцийн заасны дагуу³ “Монгол Улс” тэмдэглэгээ (картын зүүн дээд өнцөгт хөх дэвсгэр дээр цагаан үсгээр);

Картын төрлийн болон хэрэглэгдэх улсын нэршлүүд монгол хэлээр “Аж ахуйн нэгжийн карт Монгол Улс” (картын дээд хэсэгт);

Мэдээлэл байрлах байрлах хэсгүүд:

байрлал “1.” – тээврийн хэрэгсэл эзэмшигчийн (байгаа тохиолдолд) нэр, эсвэл овог, нэр, эцгийн нэр;

байрлал “2.” – тахографын ашиглалтыг хариуцахаар томилогдсон хуулийн этгээдийгн овог;

байрлал “3.” – байрлал “2.”-т заасан этгээдийн нэр;

байрлал “4a.” – аж ахуйн нэгжийн картын хүчинтэй хугацаа эхлэх огноо;

байрлал “4b.” – аж ахуйн нэгжийн картын хүчинтэй хугацаа дуусах огноо;

байрлал “4c.” – аж ахуйн нэгжийн картыг үйлдвэрлэгч байгууллагын нэршил;

байрлал “5b.” – аж ахуйн нэгжийн картын дугаар;

байрлал “6.” – тээврийн хэрэгсэл эзэмшигчийн, эсхүл байрлал “2.”-т заасан этгээдийн хувийн гарын үсэг;

байрлал “7.” – тээврийн хэрэгсэл эзэмшигчийн байршлын, эсхүл байнгын оршин суух (түр оршин суух) хаяг;

Аж ахуйн нэгжийн картын дугаар дараах бүтэцтэй байна: MGL P XXXXXXXXXXXX
x1 x2 x3,

Тайлбар:

MGL – “Монгол Улс” гэсэн тогтсон тэмдэглэгээ;

P – аж ахуйн нэгжийн картын тогтсон тэмдэглэгээ;

XXXXXXXXXX – аж ахуйн нэгжийн картын дугаар дарааллын арван оронтой байх бөгөөд тухайн дугаар нь картыг нөхөн олгох болон шинэчлэхэд өөрчлөгдөхгүй.

X¹ – аж ахуйн нэгжийн картын тооны индекс (0-9 ба A-Z утга хэрэглэгдэх) бөгөөд тээврийн хэрэгслийн тухайн эзэмшигчид нэмж олгосон аж ахуйн нэгжийн картын тоогоор өснө;

X² – аж ахуйн картын солилтын индекс (0-9 ба A-Z утга хэрэглэгдэх) бөгөөд аж ахуйн нэгжийн карт нөхөн олгогдсон тохиолдолд өсөх бол шинэчилсэн (шинэ хугацаатай олгосон) тохиолдолд индекс тэглэгдэнэ;

X³ – аж ахуйн нэгжийн картын шинэчлэлтийн индекс (0-9 ба A-Z утга хэрэглэгдэх) бөгөөд аж ахуйн нэгжийн картыг шинэ хугацаагаар олгох тохиолдолд дарааллан өснө.

5. Аж ахуйн нэгжийн картын ар хэсэгт дараах мэдээлэл байрлана. Үүнд:
Энэ журмын 4-д дурьдсан байршлуудын тэмдэглэгээ;

аж ахуйн нэгжийн картыг үйлдвэрлэгч байгууллагын мэдээлэл, албан ёсны хаяг.

6. Засвар үйлчилгээний картын нүүр хэсэгт дараах мэдээлэл байрлана:

1968 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн Замын хөдөлгөөний тухай конвенцийн дагуу³ “Монгол Улс” тэмдэглэгээ (картын зүүн дээд өнцөгт хөх дэвсгэр дээр цагаан үсгээр);

Картын төрлийн болон хэрэглэгдэх улсын нэршлүүд монгол хэлээр “Засвар үйлчилгээний карт Монгол Улс” (картын дээд хэсэгт);

Мэдээлэл байрлах хэсгүүд:

байрлал “1.” – засвар үйлчилгээний газрын нэр;

байрлал “2.” – тахографын засвар үйлчилгээг хариуцахаар томилогдсон хуулийн этгээдийн овог;

байрлал “3.” – байрлал “2.”-т заасан этгээдийн нэр;

байрлал “4a.” – засвар үйлчилгээний картын хүчинтэй хугацаа эхлэх огноо;

байрлал “4b.” – засвар үйлчилгээний картын хүчинтэй хугацаа дуусах огноо;

байрлал “4c.” – засвар үйлчилгээний картыг үйлдвэрлэгч байгууллагын нэр;

байрлал “5b.” – засвар үйлчилгээний картын дугаар;

байрлал “6.” – байрлал “2.”-т заасан этгээдийн хувийн гарын үсэг;

байрлал “7.” – засвар үйлчилгээний газрын албан ёсны хаяг;

Засвар үйлчилгээний картын дугаар дараах бүтэцтэй байна: MGL M
XXXXXXXXXX^{X¹ X² X³},

Тайлбар:

MGL – “Монгол Улс” гэсэн тогтсон тэмдэглэгээ;

M – засвар үйлчилгээний картын тогтсон тэмдэглэгээ;

XXXXXXXXXX – засвар үйлчилгээний картын дугаар дарааллын арван оронтой байх бөгөөд картын нөхөн олгох болон шинэчлэх тохиолдолд дарааллын дугаар өөрчлөгдөхгүй.

X¹ – засвар үйлчилгээний картын тооны индекс (0-9 ба A-Z гэсэн утга)-тэй байх бөгөөд тухайн засвар үйлчилгээний цехэд нэмж олгосон засвар үйлчилгээний картын тоогоор өснө;

X² – засвар үйлчилгээний картын солилтын индекс (0-9 ба A-Z утга)-тэй байх бөгөөд засвар үйлчилгээний карт нөхөн олгогдсон тохиолдолд индекс өсөх бол шинэчилсэн (шинэ хугацаатай олгосон) тохиолдолд индекс тэглэгдэнэ;

X³ – засвар үйлчилгээний картын шинэчлэлтийн индекс (0-9 ба A-Z утга)-тэй байх бөгөөд засвар үйлчилгээний картыг шинэ хугацаагаар олгох тохиолдолд дарааллан өснө.

7. Засвар үйлчилгээний картын арын хэсэгт дараах мэдээлэл байрлана. Үүнд: Энэхүү журмын 6-д дурьдсан байршлуудын тэмдэглэгээ; засвар үйлчилгээний картыг үйлдвэрлэгч байгууллагын мэдээлэл, албан ёсны хаяг.

8. Хяналтын картын нүүр хэсэгт дараах мэдээлэл байрлана:

1968 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн Замын хөдөлгөөний тухай конвенцийн дагуу³ “MGL” гэсэн тэмдэглэгээ (картын зүүн дээд өнцөгт хөх дэвсгэр дээр цагаан үсгээр);

Картын төрлийн болон хэрэглэгдэх улсын нэр монгол хэлээр “Хяналтын карт Монгол Улс” (картын дээд хэсэгт);

Мэдээлэл байрлах хэсгүүд:

байрлал “1.” – хяналтын байгууллагын нэр;

байрлал “2.” – хяналтын байгууллагын утасны дугаар;

байрлал “3.” – хяналтын байгууллагын цахим шуудангийн хаяг;

байрлал “4a.” – хянагчийн картын хүчинтэй хугацаа эхлэх огноо;

байрлал “4b.” – хянагчийн картын хүчинтэй хугацаа дуусах огноо;

байрлал “4c.” – хянагчийн картыг үйлдвэрлэгч байгууллагын нэршил;

байрлал “5b.” – хянагчийн картын дугаар;

байрлал “6.” – хяналтын байгууллагын албан ёсны хаяг;

Хяналтын картын дугаар дараах бүтэцтэй байна: MGL K XXXXXXXXXXXX^{X1 X2 X3},

Тайлбар:

MGL – “Монгол Улс” гэсэн тогтсон тэмдэглэгээ;

K – хяналтын картын тогтсон тэмдэглэгээ;

XXXXXXXXXXXX – хяналтын байгууллагын таних тэмдэг бүхий арван оронтой серийн дугаар (Монгол Улсын Тээврийн цагдаагийн албаны албан хаагч бол TTSA, харин Автотээврийн хяналтын улсын байцаагч бол ATHUB) хяналтын байгууллагын таних тэмдэглэгээ бүхий хяналтын картын арван оронтой дарааллын дугаар бөгөөд картыг нөхөн олгох, шинэчлэх тохиолдолд өөрчлөгдөхгүй.

X¹ – хяналтын картын тооны индекс (0-9 ба A-Z утга)-тэй байх бөгөөд тухайн хяналтын байгууллагад нэмж олгосон хянагчийн картын тоогоор картын индекс өснө;

X^2 – хяналтын картын солилтын индекс (0-9 ба A-Z утга)-тэй байх бөгөөд хянагчийн карт нөхөн олгогдсон тохиолдолд индекс өсөх бол шинэчилсэн (шинэ хугацаатай олгосон) тохиолдолд индекс тэглэгдэнэ;

X^3 – хяналтын картын шинэчлэлтийн индекс (0-9 ба A-Z утга)-тэй байх бөгөөд хянагчийн картыг шинэ хугацаагаар олгох тохиолдолд дарааллан өснө.

9. Хяналтын картын арын хэсэгт дараах мэдээлэл байрлана. Үүнд:

Энэхүү журмын 8-д дурьдсан байршлуудын тэмдэглэгээ;
хяналтын ажилтны картыг үйлдвэрлэгч байгууллагын мэдээлэл, албан ёсны хаяг.

10. Санал болгож буй тахографын картуудын өнгө загваруудыг Хавсралт 1-йн Шаардлагууд хэсэгт дурьдсан байгаа.

11. Картууд дараах үзүүлэлттэй байна:

- 1) хэмжээ – ID-1 (CR80) ⁴;
- 2) ашиглагдах материал – поликарбонат;
- 3) картын төрөл – контактын

12. Картууд нь полиграфи, голографи, мэдээллийн, микропроцессорын болон полиграфи бүтээгдэхүүний хамгаалтын бусад нууцлалын хоёроос цөөнгүй элементийг ашиглан хийгдсэн, хуурамчаар үйлдэхээс хамгаалагдсан полиграфи бүтээгдэхүүн байна.

13. Карт дээрх бичвэр дараах өнгийн дэвсгэр дээр хэвлэгдсэн байна:

- 1) жолоочийн карт: цагаан;
- 2) хянагчийн карт: цэнхэр;
- 3) засвар үйлчилгээний карт: улаан;
- 4) аж ахуйн нэгжийн карт: шар.

14. Карт дахь мэдээллийн бүтэц нь шаталсан файлын систем хэлбэрээр зохион байгуулагдсан байна.

15. Картын интерфейс нь $T = 0$ болон $T = 1$ горимуудыг дэмждэг байна.

16. Карт нь тэжээлийн дараах хүчдэлд ажилладаг байна:

$$V_{cc} = 3 \text{ В } (+/-0,3 \text{ В});$$

$$V_{cc} = 5 \text{ В } (+/- 0,5 \text{ В})$$

17. Карт нь дөрвөн оронгоос бүрдэх, картыг таниулахад ашиглах PIN кодтой байна.

18. Карт нь дараах өгөгдлүүдийг хадгална:

- 1) суурилуулсан бичил процессорын таниулах өгөгдлүүд (серийн дугаар);
- 2) картын серийн дугаар;
- 3) картыг үйлдвэрлэгч байгууллагын таниулах өгөгдлүүд.

19. Жолоочийн карт нь энэхүү журмын 18-д заасан өгөгдлүүдээс гадна дараах таниулах өгөгдлүүдийг хадгална:

- 1) картын дугаар;
- 2) картыг үйлдвэрлэгч байгууллагын нэр, олгосон огноо;
- 3) картын хүчинтэй хугацааны эхлэх огноо, картын хүчинтэй хугацаа дуусах огноо;
- 4) карт эзэмшигчийн овог, нэр;
- 5) карт эзэмшигчийн төрсөн огноо;
- 6) жолооны үнэмлэхний дугаар;
- 7) жолооны үнэмлэхийг олгосон байгууллагын нэр.

20. Жолоочийн карт нь тээврийн хэрэгслийг ашигласан хугацаа бүрийг (тахографт картыг хийсэн, гаргаж авсан мөчлөгүүдийн дарааллыг ашиглалтын хугацаанд тооцно) оруулан тухайн картыг ашигласан хуанлийн хоног бүрт дараах өгөгдлүүдийн 84-өөс цөөнгүй бичилтийг хадгална:

1) тээврийн хэрэгсэл хөдөлгөөн эхэлсэн цаг, огноо (өөрөөр хэлбэл, тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд картыг анх төхөөрөмжид хийсэн, эсхүл тухайн үед ашиглалт үргэлжлэн явагдаж байсан тохиолдолд 00 цаг 00 минут) болон тээврийн хэрэгслийн гүйлтийн тоолуурын заалт;

2) тээврийн хэрэгсэл зогссон цаг, огноо (өөрөөр хэлбэл, тээврийн хэрэгслийг заасан хугацаанд ашиглахдаа картыг хамгийн сүүлд гарган авсан, эсвэл тухайн үед ашиглалт үргэлжлэн явагдаж байсан тохиолдолд 23 цаг 59 минут) болон тээврийн хэрэгслийн гүйлтийн тоолуурын заалт;

3) тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар.

21. Жолоочийн карт нь тухайн карт ашиглагдсан өдөр бүрийн мэдээлэл болон жолооч өөрийн үйл ажиллагааны талаар гараар оруулсан мэдээллийг дор дурдсанаар хуанлийн сүүлийн 28 хоногийн хугацаанд хадгална:

- 1) өгөгдөл;
- 2) өдөр тутмын ирцийн тоолуур (хуанлийн хоног тутам нэг нэгжээр ахина);
- 3) тухайн өдөр жолооч тээврийн хэрэгслээр туулсан нийт замын урт;
- 4) 00 цаг 00 минут дахь жолоочийн статус
- 5) дараах цагийн өөрчлөлтүүд:
 - жолоодлогын байдал ("багаар", "ганцаар");
 - уншигч төхөөрөмжийн байдал ("үндсэн жолооч", "ээлжийн жолооч");
 - картын байрлал ("төхөөрөмжид хийсэн", "хийгээгүй");үйл ажиллагааны төрөл ("жолоодлого", "бэлэн байдал", "ажил", "завсарлага/амралт").

22. Жолоочийн карт нь жолоодлогын цаг эхлэх болон дууссан хугацааны байршлын 42-оос цөөнгүй мэдээллийн бүртгэлийг хадгална:

- 1) мэдээлэл оруулсан огноо, цаг;
- 2) тээврийн хэрэгслийн гүйлтийн тоолуурын заалт.

23. Жолоочийн карт нь тахографт картыг хийсэн үед бичигдсэн дараах үйл явдлын талаарх өгөгдлүүдийг хадгална:

1) цаг тохирохгүй байх (уг үйл явдал тухайн картын алдаанаас үүдсэн тохиолдолд);

2) жолоодлого эхэлсний дараа картыг хийх (уг үйл явдал тухайн картын алдаанаас үүдсэн тохиолдолд);

3) карт ашиглалтын төгсгөлийн үеийг буруу гүйцэтгэсэн (уг үйл явдал тухайн картын алдаанаас үүдсэн тохиолдолд);

4) цахилгаан тэжээлийн тасралт;

5) хөдөлгөөний өгөгдлүүдийн алдаа;

6) хамгаалтыг эвдэх оролдлогууд;

24. Жолоочийн карт нь Заалт 29-д заасны дагуу дараах зургаан төрлийн үйл явдал тус бүрийн талаарх сүүлчийн өгөгдлүүдийг хадгална:

1) үйл явдлын код;

2) үйл явдлын эхэллийн огноо, цаг (эсвэл тухайн үйл явдал үргэлжилж байх үед картыг хийсэн үеийн);

3) үйл явдлын төгсгөлийн огноо, цаг (эсвэл тухайн үйл явдал үргэлжилж байх үед картыг гаргасан үеийн);

4) тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар;

5) “цаг тохирохгүй байх” үйл явдлын тохиолдолд:

үйл явдлын эхлэлийн огноо, цаг (өмнөх тээврийн хэрэгслээс картыг гаргаж авсан огноо, цагтай давхцаж байвал);

үйл явдлын төгсгөлийн огноо, цаг (тухайн үед ашиглагдаж буй тээврийн хэрэгсэлд картыг хийсэн огноо, цагтай давхцаж байвал);

тээврийн хэрэгслийн талаарх өгөгдлүүд (тухайн үйл явдал хамаарах тээврийн хэрэгсэл ашиглалтын явцад байгаа бол);

6) “картын ашиглалтын сүүлчийн үйлдлийн төгсгөл буруу хийгдсэн” үйл явдлын үед:

үйл явдлын эхлэлийн огноо, цаг (картын ашиглалтын сүүлчийн үйлдлийн төгсгөл буруу хийгдсэн үйл явдлын үед картыг оруулсан огноо, цагтай хамааралтай);

үйл явдлын төгсгөлийн огноо, цаг (ашиглалтынх нь үед тухайн үйл явдал гарсан тухайн картыг оруулсан огноо, цагтай хамааралтай);

тээврийн хэрэгслийн талаарх өгөгдлүүд (картын ашиглалтын үйлдлийн төгсгөл буруу хийгдсэн үйл явдал гарсан тухайн тээврийн хэрэгсэлтэй хамааралтай).

25. Жолоочийн карт нь тахографт картыг хийсэн үед илэрсэн дараах гэмтлүүдийн талаарх өгөгдлүүдийг хадгална:

1) картын ажиллагаанд саатал гарах (уг үйл явдал тухайн картын алдаанаас үүдсэн тохиолдолд);

2) тахографын ажиллагаанд саатал гарах.

26. Жолоочийн карт нь картын болон тахографын ажиллагаанд гарсан хамгийн сүүлд бүртгэгдсэн 12 эвдрэл, гэмтлийн талаарх өгөгдлүүдийг хадгална:

1) гэмтлийн код;

2) гэмтэл үүссэн огноо, цаг (эсвэл картыг оруулах үед гэмтэл үүссэн байсан бол картыг оруулах үеийн огноо, цаг);

3) гэмтлийг арилгасан огноо, цаг (эсвэл картыг гаргах үед гэмтэл арилаагүй байсан бол картыг гаргасан огноо, цаг);

4) тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар.

27. Жолоочийн карт нь баталгаажуулалтын үйл ажиллагааны талаарх өгөгдлүүдийн нэг бичилтийг хадгална:

1) шалгалтын огноо, цаг;

2) хяналтын байгуулгын картын дугаар болон картыг үйлдвэрлэгч байгууллагын нэр;

3) шалгалтын төрөл (дэлгэц дээр мөн/эсвэл хэвлэж гаргах, мөн/эсвэл өгөгдлүүдийг суурин төхөөрөмжөөс хуулах, мөн/эсвэл өгөгдлүүдийг картаас хуулах);

4) өгөгдлүүдийг ачаалах хугацаа (ачаалсан тохиолдолд);

5) тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар.

28. Жолоочийн карт нь тухайн картыг ашиглаж эхэлсэн үед хамаарах тээврийн хэрэгслийн талаарх өгөгдлүүдийг хадгална:

1) ашиглалтын эхлэлийн огноо, цаг (картыг оруулах үе);

2) тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар.

29. Жолоочийн карт нь картыг төхөөрөмжид хийсэн байх үеийн “үл хамаарах” болон “усан гаталгаа/галт тэргээр тээвэрлэгдэх” нөхцлийн бүртгэгдсэн дараах 56 тохиолдлуудын талаарх өгөгдлүүдийг хадгална:

1) оруулсан огноо, цаг;

2) нөхцлийн төрөл.

30. Засвар үйлчилгээний карт нь тахографыг идэвхжүүлэхэд шаардлага бүхий өгөгдлүүдийг хадгална.

31. Засвар үйлчилгээний карт нь дараах өгөгдлүүдийг хадгална:

1) картын дугаар;

2) картыг үйлдвэрлэгч байгууллагын нэр, олгосон огноо;

3) картын хүчинтэй хугацааны эхлэх огноо, картын хүчинтэй хугацаа дуусах огноо;

4) засвар үйлчилгээний газрын нэр;

5) засвар үйлчилгээний газрын албан ёсны хаяг;

6) эзэмшигчийн овог, нэр;

7) тээврийн хэрэгслийн мэдээллийн дөрвөн бичилт;

8) тээврийн хэрэгсэл жолоодох хугацааны эхлэлийн болон/эсвэл төгсгөлийн цагийн талаарх өгөгдлийн гурван хос бичилт;

9) үйл явдал ба гэмтлийн талаарх;

10) Заалт 28-д заасан сүүлчийн гурван бичилтийн талаарх, мөн Заалт 31-д заасан төрөл тус бүрийн сүүлчийн зургаан гэмтлийн талаарх;

11) шалгалтын үйл ажиллагааны талаарх;

12) “үл хамаарах” болон “усан гаталгаа/галт тэргээр тээвэрлэгдэх” нөхцлүүдийн хоёр бичилт.

32. Засвар үйлчилгээний карт нь дараах өгөгдлүүдийг хадгална:

1) засвар үйлчилгээний картыг ашиглан суурилуулалтын өгөгдөлд хийсэн тохируулгын тоо, сүүлийн өгөгдлийг хуулж авснаас хойшхи суурилуулалтын өгөгдөлд хийсэн тохируулгын тоо;

2) Суурилалтын өгөгдөлд хийсэн сүүлийн 88 тохиргооны талаарх дараах мэдээллүүдийн:

суурилуулалтын өгөгдлүүдийн тохиргооны төрөл: идэвхжүүлэлт, эхний суурилуулалт, суурилуулалт, тохируулга;

тээврийн хэрэгслийн таниулах өгөгдлүүд;

тохируулгын талаарх өгөгдлүүд: хурд хязгаарлагч төхөөрөмжийн, гүйлтийн тоолуурын заалтын (шинэ ба өмнөх заалтууд), огноо ба цагийн (шинэ ба өмнөх заалтууд);

тахографын таниулах өгөгдлүүд.

33. Хяналтын карт нь дараах таниулах өгөгдлүүдийг хадгална:

1) картын дугаар;

2) картыг үйлдвэрлэгч байгууллагын нэр, олгосон огноо;

3) картын хүчинтэй хугацааны эхлэх огноо, картын хүчинтэй хугацаа дуусах огноо;

4) хяналтын байгууллагын нэр;

5) хяналтын байгууллагын албан ёсны хаяг.

34. Хяналтын карт нь шалгалтын ажиллагааны талаарх дараах өгөгдлүүдийн 230 бичилтийг хадгална:

1) шалгалтын огноо, цаг;

2) шалгалтын төрөл (дэлгэц дээр мөн/эсвэл хэвлэж гаргах, мөн/эсвэл өгөгдлүүдийг суурин төхөөрөмжөөс хуулах, мөн/эсвэл өгөгдлүүдийг картаас хуулах);

3) өгөгдлүүдийг ачаалах хугацаа (ачаалсан тохиолдолд);

4) тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар;

5) шалгагдсан жолоочийн картын дугаар болон картыг үйлдвэрлэгч байгууллагын нэр.

35. Аж ахуйн карт нь дараах таниулах өгөгдлүүдийг хадгална:

1) картын дугаар;

2) картыг үйлдвэрлэгч байгууллагын нэр болон картыг олгосон огноо;

3) картын хүчинтэй хугацааны эхлэх огноо, картын хүчинтэй хугацаа дуусах огноо;

4) тээврийн хэрэгслийн эзэмшигчийн нэр эсвэл (байгаа тохиолдолд) овог, нэр ба эцгийн нэр;

5) тээврийн хэрэгсэл эзэмшигчийн харъяалал, эсвэл байнгын оршин суух (түр оршин суух) хаяг.

36. Аж ахуйн нэгжийн карт нь тээврийн хэрэгсэл эзэмшигчийн үйлдлүүдийн талаарх дараах өгөгдлүүдийн 230 бичилтийг хадгална:

1) гүйцэтгэсэн үйлдлийн огноо, цаг;

2) үйлдлийн төрөл (суурин төхөөрөмжид блок хийх мөн/эсвэл блок гаргах, мөн/эсвэл өгөгдлүүдийг суурин төхөөрөмжөөс ачаалах, мөн/эсвэл өгөгдлүүдийг картаас ачаалах);

3) өгөгдлүүдийг хуулах хугацаа (хуулсан тохиолдолд);

4) тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар;

5) жолоочийн картын дугаар болон картыг үйлдвэрлэгч байгууллагын нэр (картаас өгөгдлүүдийг хуулсан тохиолдолд).

I. Тахограф болон картын үйлдвэрлэл, идэвхжүүлэлт ба ашиглалт

37. Тахограф нь тээврийн хэрэгслийн хурд ба хөдөлгөөний маршрутын, тээврийн хэрэгслийн жолоодсон цаг ба тээврийн хэрэгслийн жолооч нарын амралтын цагийн, жолооч нарын ажил амралтын горимын талаарх өгөгдлүүдийг засваргүй хэлбэрээр бүртгэх, хамгаалагдсан өгөгдлүүдэд хавсаргах баталгаажсан цахим гарын үсэг үүсгэх, мөн шифрлэх (криптографик) хэрэгслүүдийг ашиглан хамгаалагдсан мэдээлэлд нэвтрэх эрхийг зааглах үүрэгтэй болно.

38. Тахографын картын загвар нь тахографын загварын мэдээллийн жагсаалтад багтсан бүх тахографын загварт ашиглах үед тавигдах шаардлагад нийцсэн байх ёстой.

Тахографын загвар нь картын загварын мэдээллийн жагсаалтад багтсан бүх картын загварт хэрэглэхэд тавигдах шаардлагад нийцсэн байх ёстой

39. Тахографын картын үйлдвэрлэл, нийлүүлэлт болон техник үйлчилгээг холбогдох журмын дагуу гүйцэтгэнэ.

40. Картын үйлдвэрлэл, зохион бүтээх ба картын баталгаажсан гэрчилгээг олгох олголтыг, эдгээр ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бусад үүргүүдийг эрх бүхий байгууллагаас эрх олгогдсон байгууллага гүйцэтгэнэ.

41. Түлхүүр мэдээллийг картууд руу хуулах ажлыг карт болон тахографын үйлдвэрлэгч байгууллага гүйцэтгэнэ.

42. Тахографын картуудын баталгаажсан цахим гарын үсгийн түлхүүрийг бүтээхэд холбогдох дүрэм, журамд заасан шаардлагад нийцсэн хэрэгслүүдийг ашиглана.

43. Баталгаажсан цахим гарын үсгийн болон картуудын түлхүүрүүдийн баталгаажсан гэрчилгээний хүчинтэй хугацаа картуудын хүчинтэй хугацаанаас ихгүй байна:

1) жолоочийн картын баталгаажсан гэрчилгээний хүчинтэй хугацаа гурван жилээс ихгүй байна;

2) засвар үйлчилгээний картын баталгаажсан гэрчилгээний хүчинтэй хугацаа нэг жилээс ихгүй байна;

3) хяналтын картын баталгаажсан гэрчилгээний хүчинтэй хугацаа хоёр жилээс ихгүй байна;

4) аж ахуйн нэгжийн картын баталгаажсан гэрчилгээний хүчинтэй хугацаа гурван жилээс ихгүй байна.

44. Картуудын баталгаажсан гэрчилгээний хүчинтэй хугацааг картын баталгаажсан гэрчилгээн хүчинтэй төгөлдөр болсон хугацаанаас эхлэн картын баталгаажсан гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссанаас хойш 24 цаг 00 минут 00 секундээр тоологдоно.

45. Тахограф нь өгөгдлүүдийг гадны зөөвөрлөгч рүү хуулах ажиллагаатай байна.

46. Холбогдох хүсэлт болон тодорхойлогдсон эрхийн дагуу гадны зөөвөрлөгч рүү буулгахдаа:

- 1) суурин төхөөрөмжөөс;
- 2) тахографын картаас.

47. Тахограф нь дараах зургаан төрлийн өгөгдлийг дамжуулдаг байна:

- 1) ерөнхий;
- 2) заасан огноогоор үйл ажиллагааг;
- 3) үйл явдлууд ба гэмтлүүд;
- 4) хурдны горимын мэдээллүүд;
- 5) техникийн өгөгдлүүд;
- 6) картаас өгөгдлүүдийг буулгах.

47.1. Гадны зөөвөрлөгчинд хадгалагдах өгөгдлүүдийн үнэн зөв, бүрэн байдлыг хянах зорилгоор өгөгдлүүдийг байршуулах үед түүн дээр энэхүү журамд заасны дагуу цахим гарын үсгээр баталгаажуулна.

48. Байршуулж буй мэдээлэл нь эх үүсвэрийн (тахографын, картын) таниулах өгөгдлүүд болон зохих баталгаажсан гэрчилгээг агуулсан байна.

49. Байршуулж буй өгөгдлүүдийн үнэн зөв, бүрэн байдлыг шалгахдаа баталгаажсан гэрчилгээн дотор байх баталгаажсан цахим гарын үсгийг шалгах нээлттэй түлхүүрийн тусламжтай хийгдэнэ.

50. Өгөгдлүүд гадны төхөөрөмж рүү нэг файл хэлбэрээр ганц үйлдлээр буулгана.

51. Суурийн төхөөрөмжөөс өгөгдлүүдийг буулгахдаа тахограф нь дараах шаардлагыг хангана:

- 1) уншигч төхөөрөмжид хийсэн картыг таниулах, байршуулах функц болон байршуулсан өгөгдөлд холбогдох хандалтын эрхийг баталгаажуулах;
- 2) гадны зөөвөрлөгч болон суурин төхөөрөмжийн хооронд холбогдох хамгаалагдсан шугам үүсгэх боломжтой байх;
- 3) байршуулах өгөгдлийн сонголт хийх;
- 4) шаардлагатай өгөгдлүүдийг гадны зөөвөрлөгч дээр бичих;
- 5) байршуулах үйлдлийг дуусгах.

52. Тахограф нь гадны зөөвөрлөгчүүдийг дэмжиж ажиллах бололцоотой байна.

53. Тахограф нь картаас өгөгдлүүдийг ачаалах явцад уншигч төхөөрөмжөөр картыг гаргахаас эсвэл шинээр ачаалахаас өмнө дахин эхлүүлэх үйлдлийн чадвартай байна.

54. Тахограф нь бэлтгэл үйлдлүүдийг гүйцэтгэдэг байна:

- 1) гарын үсэг зурагдаагүй өгөгдлүүдийн файлд;
- 2) гарын үсэг зурагдсан өгөгдлүүдийн файлд;
- 3) өгөгдлүүдийн тоолуурыг дахин тэглэхэд.

55. Тахограф нь дараах шаардлагуудын дагуу өгөгдлүүдийг татаж авна:

- 1) байтуудын дарааллыг, мөн байт болгоны доторх битүүдийн дарааллыг хадгалснаар картаас зөөгдөж буй өгөгдлүүдийн заалт хэвээр байна;
- 2) картаас нэг үйлдлээр ачаалагдаж байгаа бүх файлууд гадны зөөвөрлөгчид нэг файлын хэлбэрээр хадгалагдана.

Тахографын картын хийцийн маягтууд

Жолоочийн карт

МУ	Жолоочийн карт	Монгол Улс
6.	1..... 2..... 3. ОН САР ӨДӨР 4а. ОН САР ӨДӨР 4b. ОН САР ӨДӨР 5а. 5с. 7. 8.	

1. Овог
2. Нэр
3. Төрсөн огноо
- 4а. Картыг олгосон огноо
- 4б. Картын хүчинтэй хугацаа
- 4с. Карт үйлдвэрлэгч байгууллагын нэр
- 5а. Жолоочны үнэмлэх дугаар
- 5с. Картын дугаар
6. Зураг
7. Гарын үсэг
8. Албан ёсны оршин суугаа хаяг

..... (карт үйлдвэрлэгч байгууллагын нэр)-д(карт үйлдвэрлэгч байгууллагын хаяг)-аар буцаан хүргүүлнэ.

Аж ахуйн нэгжийн карт

МУ

Аж ахуйн нэгжийн карт

Монгол Улс

1.....

2.....

3. ОН САР ӨДӨР

4а. ОН САР ӨДӨР 4б. ОН САР ӨДӨР

5а.

5с.

6.

7.

1. Тээврийн хэрэгсэл эзэмшигчийн нэр
2. Овог
3. Нэр
- 4а. Картыг олгосон огноо
- 4б. Картын хүчинтэй хугацаа
- 4с. Карт үйлдвэрлэгч байгууллагын нэр
- 5с. Картын дугаар
6. Гарын үсэг
7. Албан ёсны оршин суугаа хаяг

..... (карт үйлдвэрлэгч байгууллагын нэр)-д(карт үйлдвэрлэгч байгууллагын хаяг)-аар буцаан хүргүүлнэ.

Засвар үйлчилгээний карт

МУ

Засвар үйлчилгээний карт Монгол Улс

1.....

2.....

3. ОН САР ӨДӨР

4а. ОН САР ӨДӨР 4б. ОН САР ӨДӨР

4.с

5b.

6.

7.

1. Засварын газрын нэр
2. Овог
3. Нэр
- 4а. Картыг олгосон огноо
- 4б. Картын хүчинтэй хугацаа
- 4с. Карт үйлдвэрлэгч байгууллагын нэр
- 5с. Картын дугаар
6. Гарын үсэг
7. Албан ёсны оршин суугаа хаяг

..... (карт үйлдвэрлэгч байгууллагын нэр)-д(карт үйлдвэрлэгч байгууллагын хаяг)-аар буцаан хүргүүлнэ.

Хяналтын карт

МУ

Хяналтын карт

Монгол Улс

1.....

2.....

3. ОН САР ӨДӨР

4а. ОН САР ӨДӨР 4б. ОН САР ӨДӨР

4.с

5b.

6.

1. Хяналтын байгууллагы нэр

2. Хяналтын байгууллагын холбоо барих дугаар

3. Хяналтын байгууллагын цахим хаяг

4а. Картыг олгосон огноо

4б. Картын хүчинтэй хугацаа

4с. Карт үйлдвэрлэгч байгууллагын нэр

5с. Картын дугаар

6. Албан ёсны оршин суугаа хаяг

..... (карт үйлдвэрлэгч байгууллагын нэр)-д(карт үйлдвэрлэгч байгууллагын хаяг)-аар
буцаан хүргүүлнэ.